





БАТЛАВ:



ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ХҮЧИЛТӨРӨГЧИЙН КОМПРЕССОР/ НИЙЛҮҮЛЭХ НЭМЭЛТ ГЭРЭЭ

Дугаар № 512

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн яам” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Си Даблю Эм Жи Эл” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь Шинэ коронавируст халдварын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж /Багц-1: Хүчилтөрөгчийн компрессор/ нийлүүлэх төсөл арга, хэмжээнд зайлшгүй шаардлагатай дагалдах хэрэгслийг 3,084,900.0 (Гурван сая наян дөрвөн мянга есөн зуун) төгрөгөөр нийлүүлэх үнийн саналыг хүлээн зөвшөөрч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх хэсгийг үндэслэн нэмэлт гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. 2020 онд санхүүжих дүн 3,084,900.0 (Гурван сая наян дөрвөн мянга есөн зуун) төгрөг бөгөөд барааг бүрэн хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 15 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Компрессорын хучин шугаманд холбох хэрэгслэлийн иж бүрдэл	ХБНГУ	Kaesar	1
2	Компрессорын тохиргооны иж бүрдэл	ХБНГУ	Kaesar	1

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;

Тендер ба үнийн хуваарь;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/

Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.


8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга




Д.Нарантуяа

Хуулийн хэлтсийн дарга



Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга



Т.Бямбасүрэн

Хуулийн хэлтсийн гэрээний мэргэжилтэн



Д.Мөнхцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн




Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, 1 давхар 106 тоот өрөө Улаанбаатар-48, Олимпын гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Захирал



Н.Дастан

Хаяг: "Си Даблю Эм Жи Эл" ХХК, One residence хотхон, 26д байр, 1 тоот, Юнескогийн гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Утас:

И-мэйл: sales@cwmongolia.com

Дансны дугаар: 5175014053

ХААН банк

САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

Гэрээний нийт үнийн дүн /30,500,000₮/	2020 онд санхүүжих дүн 100% /төгрөг/
1	2
30,500,000₮ /гучин сая таван зуун мянга/	100%

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ГАРЧИГ

1. Нэр томъёо.....
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх.....
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
6. Барааны гарал үүслийн улс
7. Шалгалт, туршилт
8. Баглаа боодол
9. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт.....
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
11. Гүйцэтгэлийн баталгаа
12. Даатгал
13. Чанарын баталгаа, баталгаат засвар.....
14. Төлбөр.....
15. Үнэ.....
16. Хуваарийг сунгах.....
17. Алданги оногдуулах
18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
21. Маргааныг шийдвэрлэх
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
24. Гэрээнд ашиглах хэл
25. Татвар, хураамж
26. Гарчиг
27. Үүргийн гүйцэтгэл

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Нэр томъёо | 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: <ul style="list-style-type: none">(а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.(б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.(в) “Бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.(г) “Бусад үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.(д) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.(е) “Нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.(ж) “Ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.(з) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ. |
| 2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах | <ul style="list-style-type: none">2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.2.4. <i>Захиалагч</i> нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй. |
| 3. Захиалгыг өөрчлөх | 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй: |

(а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

(б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;

(в) барааг хүргэх газар.

- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид өөрчлөлт гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
6. Барааны гарал үүслийн улс 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
7. Шалгалт болон туршилт 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

- 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
- 7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
8. Баглаа боодол 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, түүний дотор гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.

11. Гүйцэтгэлийн баталгаа	11.1.	Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
	11.2.	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
	11.3.	Гүйцэтгэлийн баталгаа нь ГТН-д тусгайлан заасан бол гэрээний, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар гаргасан банкны баталгаа, засгийн газрын бонд эсхүл засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаас хэлбэрээр гаргасан баталгаа байна.
	11.4.	Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
12. Даатгал	12.1.	ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг гэрээний тусгай нөхцөлд заасан хэлбэрээр инкотермсийн нөхцлийн дагуу даатгуулна.
13. Чанарын баталгаа, баталгаат засвар	13.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
	13.2.	Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
	13.3.	Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
	13.4.	Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
	13.5.	Захиалагч нь 13.2 болон 13.4-т заасныг үл харгалзан, 13.2, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
	13.6.	Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.

14. Төлбөр	14.1.	Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд дурдана.
	14.2.	Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
	14.3.	ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
	14.4.	Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
15. Үнэ	15.1.	Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. Гэрээний тусгай нөхцөлийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
16. Хуваарийг сунгах	16.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
	16.2.	Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно: (а) захиалагч 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн; (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно); (в) 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл; (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон. Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэх, арилгахын тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
	16.3.	Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
17. Алданги оногдуулах	17.1.	Энэхүү гэрээний 23 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч гэрээг 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.

18. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй: (а) Нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй; (б) Нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй; (в) Нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй; (г) Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авилгал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална. 18.2. 18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах	19.1. Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрх, үйл ажиллагааг хөндөхгүй.
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах	20.1. Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана. 20.2. Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ: (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
21. Маргааныг шийдвэрлэх	21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.

	21.2.	Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал	22.1.	Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
	22.2.	Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
23. Гэрээний үүргийг шилжүүлэх	23.1.	Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
24. Гэрээнд ашиглах хэл	24.1.	Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
	24.2.	24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
25. Татвар болон хураамж	25.1.	Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
26. Гарчиг	26.1.	Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
27. Үүргийн гүйцэтгэл	27.1.	Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН - 1)	1.1 (д) 1.1 (ж)	Захиалагч нь: <i>Эрүүл мэндийн яам</i>
2. Шалгалт туршилт	7.0	Барааг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн хүлээн авах комисс шалгаж авах ба шаардлагатай бол үйл ажиллагааны туршилтуудыг хийнэ. Угсарч, суурилуулж, тохируулга, сургалт хийж хүлээлгэн өгнө.
3. Баглаа боодол (ГЕН - 8)	8.0	Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдрэх гэмтэхээс урьдчилан сэргийлэх баглаа боодлоор хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна.
4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)	9.0 9.3	ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: “Монгол Улсын гаднаас санал болгосон бараа (нөхцөл СИП): Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад утсан холбоогоор мэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, тээврийн хэрэгслийн нэр, тээврийн баримтын дугаар, ачсан боомт, боомтоос гарах огноо, буулгах боомт зэргийг дурдана. Нийлүүлэгч дараах баримт бичгийг захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт; 3) даатгалын гэрчилгээ; 4) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 5) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ; 6) Барааны гарал үүслийн гэрчилгээ.
5. Гүйцэтгэлийн баталгаа	11.1	Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна. Гэрээний үүргийн биелэлтээс хамаарч захиалагч талд учирсан бүхий л хохирлыг үл маргах журмаар гүйцэтгэлийн баталгаагаар хангуулах бөгөөд гүйцэтгэлийн баталгаанаас давсан дүнг нэхэмжилнэ.
6. Даатгал (ГЕН - 12)		Хэрэв барааг Монгол Улсын гаднаас санал болгож импортлох бол боомтоос барааг хүргэх цэг хүртэлх тээврийн эрсдэлийн даатгал, агуулахад хадгалах бол хадгалалтын эрсдлийн даатгалаар тус тус даатгах ба даатгалын хураамжын төлбөрийг гэрээний үнэд тооцон гүйцэтгэгч тал төлнө.
7. Баталгаат засвар (ГЕН-13)		Баталгаат засварын хугацаа 2 жил байна.
8. Төлбөр (ГЕН - 14)		ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

"Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ.

1. Урьдчилгаа төлбөр: Урьдчилгаа төлбөр олгохгүй.
2. Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Бараа ачигдсаны дараа төлбөр төлөхгүй
3. Барааг хүлээн авахад төлөх төлбөр: Ирсэн барааны гэрээний үнийн **100 хүртэлх хувьтай** тэнцэх дүнг бараа ирж бүрэн хүлээлгэн өгснөөс хойш **30** хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.

9. Алданги
оногдуулах (ГЕН
- 17)

Алданги оногдуулах хувь: *нэг хоногт 0.05 хувь байна.*

Алдангийн нийт дүн: *Гэрээний гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.*

10. Маргааныг
шийдвэрлэх (ГЕН
– 21)

Захиалагч болон нийлүүлэгч нь талуудын хооронд гарсан маргааныг Монгол улсын хуулийн дагуу шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.